

**Монгол орчуулгын түүхэнд хятадаас  
орчуулсан зохиол бүтээлийн эзлэх байр суурийн тойм**

*Ш. Эгшиг (МУИС)*

0. Оршил

1. Монголчууд хэдий үеэс хятадаас ном зохиол орчуулах болох болов?
2. Хятадаас орчуулсан зохиолд монголчуудын Бэнсний үлгэр холбогдох нь
3. Хятадаас орчуулсан зохиол бүтээлийн сэдэв зүйл болон орчуулгын гол төвүүдийн тухай

0. Монголоор орчуулсан зохиол бүтээлийн уламжлалыг авч үзвэл цаг хугацааны хувьд харьцангуй дээр үед хамаарч, орон зайн хувьд Ази, Европ дахины олон улс ороны ном судрыг орчуулж ирсэн нь байдал харагддаг. Хэдийгээр монгол уг орчуулгаараа бидний үед хурэлцэн ирээгүй боловч бараг монгол аман зохиол мэт болсон буюу амаар уламжлан ирсэн олон сэдэв, өгүүлэлмж үүний батлагаа болж өгдөгийг манай ахмад эрдэмтэд нэг бус удаа тэмдэглэсээр иржээ. Тухайлбал: "Калила Димна хоёр" зэрэг перс зохиолыг дундад зууны үеэс монголчууд хэлэлцсээр ирсэн, Турфаны олдворын дотор Македоны Александрын тухай зохиолыг уншиж байсны баримт олдсоноос гадна араб хувилбараар "Сулхарнайн тууж" хэмээх нэрээр ам дамжин өгүүлэлдсээр ирсэн, манай бараг бүх нутгаар Эртний Герегийн зохиолч Хомерийн "Одиссей" туульд гардаг өгүүлэмжүүдийг үлгэрчлэн ярьдаг тухай академич Ринчен удаа дараа тэмдэглэж он цагийн хувьд нэлээд эрт үед хамаарна хэмээн үзсэн нь буй<sup>1</sup>.

<sup>1</sup> Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 371-372; Й. Ринчен, *К истории древних культурных связей монголов с другими народами по данным монгольского фольклора*, - Роль кочевых народов в цивилизации Центральной Азии, Улан-Батор, 1974, стр. 261.

Монгол орчуулгын судлагааг авч үзвэл нэгд, түүхэн уламжлалын талаас, хоёрт, монгол орчуулгын хэл найруулгын талаас авч үзсэн гэж ерөнхийд нь хоёр хувааж болмоор санагддаг.

Монгол орчуулгын түүх, уламжлалд холбогдох ерөнхий асуудлаар академич Ринчен, төвөдөөс орчуулсан уран зохиолын талаар Л. Хүрэлбаатар, Д. Ёндон, хятадаас орчуулсан уран зохиолын талаар Э. Түмэнжаргал, (тухайн үеийн нэрээр) Зөвлөлтийн эрдэмтэн Б. Л. Рифтин, В. И. Семанов, Францын монголч-нангиадач эрдэмтэн Франсуаз Обэн (Françoise Aubin) зэрэг гадаад дотоодын олон эрдэмтэн тусгайлан судлаж ном өгүүлэл бичжээ<sup>2</sup>.

Монгол орчуулгын зохиолын хэл, найруулга, нэр томъёо болон өвөрмөц хэллэгийн оноолт, орчуулгын онол, орчуулах туршилгын талаар дээр дурдсан монгол эрдэмтдээс гадна академич Ц. Дамдинсүрэн, Ж. Бадараа, Чой. Лувсанжав, Г. Аким, Н. Жамбалсүрэн, Р. Гүрбазар, А. Шархүү, Ц. Хасбаатар, Д. Дашдаваа зэрэг манай нэрт орчуулагч нар багагүй анхаарч бодтой баримт түшиж бичсэн олон өгүүлэл нь гарчээ<sup>3</sup>. Энд өгүүлэн буй монгол орчуулгын хэл найруулгын талаархи бүтээлүүд нь тухайн цаг үеийн хэрэгцээ шаардалгаас үүдэж гол төлөв орос хэлнээс орчуулсан орчуулгын зохиол, түүний жишээ баримтыг түлхүү анхаарсан байдаг.

Дээр дурдсан бүтээлүүдийг ерөнхийд нь авч үзвэл, төвөд болон орос хэлнээс орчуулсан ном зохиолтой жишихэд хятадаас орчуулсан бүтээлтэй холбогдох судлагаа харьцангуй бага бөгөөд систем тогтолцоотой бус хэсэг бусаг байдалтай харагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй буй заа. Үүнд харьцангуй бага гэж үзэж буй судлагаанд гол төлөв уран зохиолын орчуулгын талаархи судлагаа зонхилож байна.

---

<sup>2</sup> Ринчен, *Ойратские переводы с китайского*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXX, I, Warszawa, 1966, стр. 59-73; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 371-386; Ринчен, *Марк твений минь махы нь идэж дээ*, Эмхтгэн эрхэлж Оршилыг бичсэн Г. Аким, Улаанбаатар, 1991, 230 хуудас; Д. Ёндон, *Сказочные сюжеты в памятниках тибетской и монгольской литератур*, Москва, 1989; Л. Хүрэлбаатар, *Монгол орчуулгын товчоон*, Улаанбаатар, 1995; Э. Түмэнжаргал, *Тансан ламын баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх гэдэг зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь*, - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 175-210-р тал; Э. Түмэнжаргал, *Сүн улсын хүйтэн уулын бичиг* - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 211-227-р тал; Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 234-279; Boris Rifting, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 213-262; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209-212.

<sup>3</sup> *Орчуулах эрдэм* (цуврал), Улаанбаатар, 1972, 1989; Р. Гүрбазар, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, Улаанбаатар, 1996; *Орчуулгын хэл найруулгын тухай өгүүлүүд*, Улаанбаатар, 1996.

## 1. Монголчууд хэдий үеэс хятадаас ном зохиол орчуулах болох болов?

Энэ асуултад хариулахын тул улс төр, соёлын хүрээнд нангиадын соёл боловсрол аль нэгэн байдлаар харьцангуй нөлөөтэй байж болох түүхэн үе үеэр товчхон авч үзэх хэрэгтэй болно.

Ийм үеийн хамгийн түрүүнд Хүннү нар хамаарна. Хятадаас ном зохиол орчуулж байсан гэх баримт энэ хэр хэдийгээр байхгүй боловч улс төр, эдийн засагийн хувьд тодорхой харилцаа холбоотой байсны учир хятад хэлнээс орчуулах үйл ажиллагаа огт байгаагүй гэж үзэх аргагүй юм.

Бидний мэдэхийн хэрээр орчуулгын үйл ажиллагаанд холбогдож болох хамгийн эртний бичигийн баримт гэвэл Сянбийн үед хамаарч байна. "Сүй шү" хэмээх түүхийн номзүйн хэсэг (32-р бөлөг)-т Сянби нарын үед гарсан сянби хэлнээ холбогдох 12 номын жагсаалт буй<sup>4</sup> бөгөөд үүнд улсын (үндэсний) хэлний сурах бичиг, толь бичиг болон намтар зохиол, дуу шүлэгийн зүйл олон байгаа нь лавтайяа тэр үед хэлний шинжлэл багагүй хөгжиж ирсэний батлагаа юм.

Сянби нарын түүхийг гүнзгий судласан доктор Г. Сүхбаатар энэ үед "... Ачлалт ном-ыг орчуулан ерөнхийдөө унших бичиг болгон хэрэглэж байжээ. Ачлалт ном-ын эл орчуулга бол монгол хэлний анхны орчуулга гэж үзэж болох байх..." гэж тэмдэглэжээ<sup>5</sup>. Энэ мэдээг Франсуаз Обен авгай батлаж байна<sup>6</sup>. Харамсалтай нь уг орчуулга бидний үед хүрэлцэн ирсэнгүй.

Хятадаас орчуулсан орчуулгад холбогдох илүү бодтой баримт гэвэл Хятаны үед холбогддог. Хятаны түүхийг бичсэн Б. Багана, Х. Пэрлээ нар тэр цагт "...Хятаны ба Хятадын судар бичигийн хүрээлэн хоёр байжээ. Хятан хүрээлэнд хятан судар бичиг зохиох орчуулгын хэрэг эрхлүүлжээ. Хятад хүрээлэнд Хятаны харъяат Хятадын бичиг, судар зохиох ажил хийж хятад эрдэмтэн сэхээтэн нараас улсын мөчих шалгаан авч эрдэмийн зэрэг олгох ажлыг эрхлүүлжээ..." хэмээн тэмдэглэсэн хэсэг буй<sup>7</sup>.

"Ляо улсын эх адагийн хэрэг" хэмээх түүхийн мэдээгээр Хятаны томоохон язгууртан нар гэртээ номын сантай байсан бөгөөд тэнд нь хятадын дөрвөн ном буюу "Зурхайт ном", "Шүлэглэлт ном", "Засагт ном", "Шажинт ном" болон энэдхэг, солонгосын утга зохиолын ном байдаг байсан хийгээд заримынх нь номын тоо түм хүрч байсан

<sup>4</sup> Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by L. Ligeti, Budapest, 1970, p. 279 (265-308).

<sup>5</sup> Г. Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал.

<sup>6</sup> Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries)*, Beijing, 1987, p. 209.

<sup>7</sup> Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 120-р тал (130 хуудас); Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 72-р тал.

хэмээжээ<sup>8</sup>. Үүнээс гадна өөрснөө цаг тооны бичиг зохиож байсны хажуугаар хятадаас "Тун-ли" хэмээх *Цаг улирлын нэвтэрхий бичиг* болон цааз хуулийн зүйлийг орчуулж байсан баримт байна<sup>9</sup>.

Хятан улс тухайн цагтаа бичиг соёлоо хөгжүүлж, таван нийслэл хот хийгээд муж бүртээ сургууль байгуулан, аян замын болон түүхэн тэмдэглэл зохиох, ном зохиол орчуулах, хэвлэх талаараа Ази дахинаа их л нөлөөтэй явж ирсэн бөгөөд 995 онд Солонгосоос хятан хэл, бичиг сурахаар хүмүүс тусгайлан ирж байсан мэдээ буй<sup>10</sup> нь үүний нэгэн нутлагаа болж өгнө.

Үүний дараа үе гэвэл Юан улсад хамаарах бөгөөд чухамхүү энэ үед хятадаас ном сударын зүйл орчуулах ажил үлэмжхэн хөгжиж<sup>11</sup> тэдгээр орчуулга нь ч уг эхээрээ бидний үед хүрэлцэн ирж хятадаас монголчлосон зохиол бүтээлийн бодот судлагдахуун болж өгдөг билээ.

Академич Д. Цэрэнсодном: 1240 онд "Да Сыюу Ян-ий" гэдэг номыг хятадаас орчуулсан гэх мэдээ буйг дурдаж бас 1264 онд хятадын сонгомол зохиол орчуулах, түүх зохиох хороо байгуулсаныг тус тус тэмдэглэсэнээс гадна 1307 онд "Ачлалт ном"-ыг Бултөмөр орчуулсныг тус тус тэмдэглэжээ<sup>12</sup>.

Юан улсын үеийг судласан манай нэрт түүхч академич Ч. Далай: Сүн улсын түүхч Сыма Гуан (1019-1086)-ы "Төрд туслах нэвтэрхий толь"- ("Цзы-чжи тун")-ийг 1269-1271 оны хооронд, христусын тооллын өмнөх 200-аад оны үед зохиогдсон Күнзийн сурталын "Ачлалт ном" - ("Сяоцзин")-г Болдтөмөр гэдэг монгол эрдэмтэн 1307 онд, "Их суртахуй бичиг" - ("Да-сюе") -г 1288 оноос өмнө тус тус орчуулж монгол болон дөрвөлжин бичгээр гаргаж байсан тухай дурджээ<sup>13</sup>.

Хятадаас монголчилосон зохиол бүтээлүүдийн дотроос орчуулсан цаг хугацаа болон удаа дараа хэдэн удаа орчуулсан, түүнээс лавтайяа таван орчуулга нь бидний үед хүрэлцэн ирсэн, бидэнд хүрэлцэн ирсэн хувилбар орчуулгуудаас хамгийн эртнийхи болох XIV зууны орчуулга нь дундад үеийн монгол хэлний байдлыг тусгасан зэргээрээ монгол орчуулгын түүхнээ онцгой байрыг эзлэдэг. Тийм ч болохоор дээр дурдсан монгол орчуулгуудаас "Ачлалт ном"-ын "анхны" гэгдэх орчуулгыг эрдэмтэн Х. Лувсанбалдан, проф. Л. Лигети (L. Ligeti), И. де Рахивильз (I. de Rachewiltz), Ф. В. Кливез (F. W. Cleaves), Хас-эрдэнэ зэрэг олон

<sup>8</sup> Ляо улсын эх адагийн хэрэг, гар бичмэл, 1-р дэвтэр, 45-46, 68, 85-р тал; 2-р дэвтэр, 21-р тал; 3-р дэвтэр, 40-р тал.

<sup>9</sup> Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 122-123-р тал (130 хуудас);

<sup>10</sup> Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 69-74-дүгээр тал.

<sup>11</sup> Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160-дугаар тал;

<sup>12</sup> Д. Цэрэнсодном, *Орчуулгын зохиолын өв уламжлалаас*, - Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972, (14 - 23-р тал) 15-р тал.

<sup>13</sup> Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160, 194-дүгээр тал;

эрдэмтэн хэлний онцлог болон орчуулгын түүхийн талаас нь тусгайлан судлажээ<sup>14</sup>.

Гэвч нарийвчлан хөөж бодвол, доктор Г. Сүхбаатар, Ф. Обен нарын үзсэнээр "Ачлалт ном"-ыг бүр анх Сянби нар орчуулсан гэж үзэх үндэслэл гарч байна<sup>15</sup>.

Юан улсын дараагаар тухайлбал: хятадын Мин улсын үед хятадаас монголчлох үйл ажиллагаа харьцангуй саарсан байдал харагддаг бөгөөд энэ нь цаанаа улс төрийн учир холбогдолтой буй заа.

Харин Чин улсын үед хятадын зохиол бүтээлийг орчуулах практикт нэгэн өвөрмөц үе эхлэсэн гэж үзэх үндэс буй. Үүнд: шууд хятад эхээс нь монголчлохын хажуугаар манж орчуулгаас нь дам монголчлох ажил багагүй хөгжсөнтэй холбоотой юм. Энэ нь нэгд, Манж нар хятад хэлэнд нэвтэрхий сайн байсан учир орчуулга нь харьцангуй сайн байсантай, хоёрт, монгол манж хоёр нэг гарал нэгтэй болохоор манжаас монголчилох нь илүү хялбар байсанаар тус тус тайлбарлагдана. Хятадын сонгодог зохиол бүтээлийн монгол орчуулгын зонхилох хувь нь чухам энэ үеэс эхлэж Богд хаант монгол улсын үеэс Ардын засагийн эхний үе хүртэл үргэлжлэсэн байдал бэлхэнээ харагддаг бөгөөд энэ талаар эрдэмтэд холбогдох судлагаандаа тэмдэглэсэн нь буй<sup>16</sup>.

---

<sup>14</sup> Х. Лувсанбалдан, *Ачлалт номын тухай*, *Studia Mongolica*, Tom. III, Fasc. 12, Улаанбаатар, 1961; I. de Rachewiltz, *The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 16, Wiesbaden, 1982, pp. 7-109; F. W. Cleaves, *The First Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 36, Budapest, 1982, pp. 69-88; F. W. Cleaves, *The second Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Documenta Barbarorum, Festschrift für Walter Heissig zum 70. Geburtstag*, Wiesbaden, 1983, pp. 272-281; L. Ligeti, *A propos de la traduction mongole préclassique de Hsiao-king*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 38, Budapest 1984, pp. 303 - 349; I. de Rachewiltz, *More about the preclassical mongolian version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 19, Wiesbaden, 1986, pp. 27- 37. Qasardeni, *Mongʻol kelen-ü Takimdayu biäg-ün üge бүтүкү yosun*, - *Erdem sinjilegen-ü sedkül, Kökeqota*, 1991, N. 2 (33), 21-27.

<sup>15</sup> Г. Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries)*, Beijing, 1987, p. 209.

<sup>16</sup> Ринчэн, *Ойратские переводы с китайского*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. XXX, 1, Warszawa, 1966, стр. 59-73; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - *Мастерство перевода 1971, Сборник восьмой*, Москва, 1971, стр. 373-377; Э. Түмэнжаргал, *Тансан ламын баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх гэдэг зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь*, - *Монголын уран зохиолын тойм, III дэвтэр*, Улаанбаатар, 1968, 175-210-р тал; Э. Түмэнжаргал, *Сүн улсын хүйтэн уулын бичиг* - *Монголын уран зохиолын тойм, III дэвтэр*, Улаанбаатар, 1968, 211-227-р тал; Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - *Литературные связи Монголии*, Москва, 1981, стр. 234-279; Boris Riffin, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries)*, Beijing, 1987, p. 213-262; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries)*, Beijing, 1987, p. 209-212.

1911 онд Хятад газар Манж Чин улс унах улс төрийн үйл явдлын өмнөхөн хятад, манж хэлэнд нэвтэрсэн монголын бичигийн хүн (стилист) Балданцэрэн билигт, Цогтбадарах хичээнгүй нар Ши Най-анийн *"Шүй ху жуан"* буюу *"Мөрний хариг"* хэмээх түүхэн романыг хятад хэлнээс орчуулсан гэдэг баттай баримт буй. Сүн улсын төрийг эсэргүүцсэн тариачдын их бослогын сэдэвтэй учир 1799 оны 3-р сард Манжийн хааны зарлигаар тусгайлан хориглосон энэ зохиолыг ийнхүү орчуулсан нь ер нэг тохиолдлыг хэрэг байгаагүй бөгөөд тухайн үедээ ихээхэн зориг гаргасан хэрэг байсан юм. Монгол улс Манж Чингийн төрөөс тусгаарлаж Сандо амбаныг монгол газраас хөөхөд энэхүү зохиолын орчуулга ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн гэж эрдэмтэд үздэг<sup>17</sup>. Энэ ташрамд уг зохиолын өөр хэд хэдэн орчуулга байдагийг дурдаж хойно тодруулан өгүүлэх болно.

Богд хаант монгол улсын үеэс Ардын засагийн эхний хэдэн жилийн хооронд хятадын олон сонгодог зохиол бүтээлийг монголчилох ажил хамгийн эрчимтэй үедээ хүрсэн байдал харагддаг нь түрүү үеийн уламжлалын эрч саараагүйтэй холбоотой буй заа. Чухам энэ үед хятадын сонгодог зохиол бүтээлийг шууд болон манжаас дам орчуулах явдал томоохон төв газраас хальж хөдөө нутагт байгуулагдсан иргэний сургуулийг дагаж хөгжсөн байна. Үүний нэг нь Сайн ноён хан аймагийн Чин сүзэгт номун хан хутагт Цэдэнбалжирын санаачилгаар түүний шавьд 1914 онд байгуулагдсан, харчин нутгаас ирсэн Лию шансан хэмээх Мөнхтогтох багштай бага сургууль ажээ. Энэ талаар холбогдох сонин мэдээ бүхий нэгэн эшлэл татая:

"...1915 онд Цэдэнбалжир өөрийн шадар бараа бологч Түмэнбаяр гэдэг хүнийг Хүрээнд явуулж Сэцэн хан аймагийн хурц ван Түдэнгийн номын сангаас монгол, манж, хятад түүх, уран зохиолын олон ном зохиолыг түр хугацаагаар авч хэрэглээд буцааж өгөхөөр өртөө улаагаар аваачиж байсан юм. Тэр аваачсан ном зохиолын монголыг нь харъяат түшмэд, бичээч нарт хугацаатай өгч албадан хуулуулж хувилж Богдын ба Сайн ноён ханы номын санд хүргүүлдэг байсан. Хятад утга зохиолын дотор дөрвөн гайхамшигт гэж нэрлэдэг зохиолын нэг *"Жин Пинмэй"* хэмээх зохиолыг манжаас орчуулсан бөгөөд ихэнхийг нь Мөнхтогтох багш өөрөө орчуулж, заримы нь манж бичиг заалган сурч байсан чадахуйц хэдэн сурагчаар орчуулгаж дараа өөрөө хянан засварлаж орчуулж дуусгасан болно. *"Хэ Ванюан"* хэмээх зохиолыг хятад хэлнээс өөрөө орчуулж гүйцэтгэсэн юм.

Шинээр орчуулсан зүйлийг шар шугамтай цаасан дээр нэг хувь, улаан шугамтай цаасан дээр нэг хувь, цулгай муутуу дээр нэг хувь бичүүлээд шар шугамтайг нь шар, улаан шугамтайг нь улаан ханлиар гоёмсог хавтас дугтуй хийж Богд ба Сайн ноёны номын санд өргөдөг, цулгуй муутуугий нь өөрийнхөө номын санд авдаг байлаа. Хурц ван Түдэнгийн номын сангаас аваачсан ном зохиолыг 1917 онд буцааж хүргүүлсэн болно.

---

<sup>17</sup> Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373.

Тэр үед Богдын номын санд өгч байсан "Жин Пинмэй", "Хэ ванюан" хэмээх зэрэг ном зохиол нь одоо Улсын Төв номын санд хадгалагдаж байна..."<sup>18</sup>

Бидний мэдэхээр христосын тооллын өмнөхи нэгдүгээр зууны үеийн Хүннү, Хан улсын харилцааны талаархи үнэн баримтад үндэслэсэн "Хэ Ванюаны бичиг" хэмээх хоёр янзын орчуулга бүхий зохиолоос хэл найруулгын хувьд илүү сайн гэж үзсэн хавсралт зураг бүхий нэг эхийг Б. Содном 1969 онд *Дурсгалт бичигийн чуулган* цувралд гэрэл зураг татаж хэвлэсэн нь дээрхи эшлэлд дурдсан буюу Чин сүзэгт номун хан хутагтын шавьд орчуулсан эх юм<sup>19</sup>.

Богд хаант Монгол Улсын үе болон Ардын засагийн эхний жилүүдэд Хятад-Манжийн боловсрол бүхий олон хүн байсан бөгөөд тэд нар хятадын сонгодог зохиол бүтээлээс монголчлох ажил үргэлжлэсээр байсан ажээ. Тэгээд ч монголын бичиг номтой хүмүүс эртний нангиадын "Шүлэглэлт ном", Ло Гуан-жуны "Гурван улсын үлгэр", Ү Чэн-энийн "Баруун этгээд зорчсон тэмдэглэл", Цао Сюэ-циний "Улаан асарын зүүд", "Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан судар хэмээх бичиг" хэмээх цоморлиг, Ляо-Жа-гийн "Ши мэргэний шийтгэсэн хэрэг" зэрэг зуугаар тоологдох роман, туужийг уншсаар байсан юм. Энэ ташрамд дурдахад хятадаас монголчилсон зохиол бүтээлийн нэлээд нь ганц бус хэд хэдэн орчуулгатай байсан гэдгийг хэлэх нь зүйтэй бөгөөд энэ талаар хойно арай тодруулан өгүүлэх болно.

1921 оны ардын хувьсгалын дараахан Судар бичигийн хүрээлэн байгуулагдаж эрдэм шинжилгээний зорилгоор монгол болон монголчуудтай шууд болон дам холбогдол бүхий олон түүх, сударыг хятад, манж хэлнээс монголчлох ажлыг бодолготой хийж иржээ.

Ийнхүү хятадын эртний сонгодог зохиол бүтээл, түүх шаштирыг монголчлох явдал мянга есөн зуун гучаад оноос тавиад он хүртэл улс төрийн шалтгаанаар саарч дараа нь БНХАУ-ын шинэ цагийн уран зохиолыг орчуулах ажилтай залгах болсон байна.

## **2. Хятадаас орчуулсан зохиолд монголчуудын Бэнсний үлгэр холбогдох нь**

Монгол үлгэрчдийн дунд нангиад түүхээс эхтэй "бэнсний үлгэр" хэмээх өвөрмиц төрөл зүйл байдаг тухай XX зууны тавиад оны дундуур Ринчен доктор орос хэлээр гардаг "Монголын мэдээ" сонинд нэг бус удаа дурдан тэмдэглэж байжээ<sup>20</sup>.

1959 онд болсон Олон улсын Монгол хэл бичигийн эрдэмтний анхдугаар их хуралд академич Ринчен "Жанр *bengsen-ü üliqer* в

<sup>18</sup> Я. Цэвэл, *Чин сүзэгт номун хан хутагтын шавь*, - Түүхийн судлал, 25-р боть, 13-р дэвтэр, Улаанбаатар, 1990, (123-152), 149-р тал.

<sup>19</sup> *Хэ ван юаны бичиг*, - Corpus Scriptorum Mongolorum, Tomus XVI, Fasc. 1, боловсруулсан Б. Содном, Redigit prof. В. Rincen, Улаанбаатар, 1969, III + 176 тал (VII талаас лавлан үзмүү).

<sup>20</sup> Зохиогч тэрхүү сонинд нийтлүүлсэн өгүүлэлүүдээ 1958 онд товхимол болгон эмхитгэжээ: Ринчен, *Из нашего культурного наследия*, Улан-Батор, 1958.

монгольском фольклоре"<sup>21</sup> гэдэг илтгэл тавьж монгол аман зохиолын дотор үлгэрчдийн өгүүлдэг нэгэн өвөрмөц төрөл зүйл байдаг тухай анх жишээ баримттайгаар тодорхойлон дурдаж улмаар дараа жил нь алдарт Лувсан хуурч (1885-1943)-ийн өгүүлсэн "Бодь мэргэн хаан" хэмээх томоохон үлгэрийг хөгжмийн ая дантай нь тэр үеийн Баруун Германд нийтлүүлсэн билээ<sup>22</sup>. Чухам энэ үеэс *bengsen-ü üliqer* гэдэг төрөл зүйлийн талаар монгол болон гадаадын эрдэмтэн анхааран судлах болсон байна<sup>23</sup>. Гэвч ийм төрөл зүйлийн зохиолыг А. П. Руднев, С. А. Кондратьев зэрэг түрүү үеийн монголч эрдэмтэд тэмдэглэн авсан баримт буй бөгөөд хэлний нь онцлогийн талаас Б. Я. Владимирцов, В. А. Алексеев нар ажин тэмдэглэсэн зүйл буй<sup>24</sup>. А. П. Руднев энэхүү төрөл зүйлийг үлгэрчийнхээ хэлсэнээр *түүхэн үлгэр* хэмээн нэрлэжээ.

Энэхүү төрөл зүйлийн үүслийг үзвэл хятадаас монголчилсон бичмэл дэвтэрээс амаар дам дам уламжласан байх бөгөөд үүний учир дэвтэр буюу бэнз (本子) хэмээх хятад үгнээс үүсч *bengsen-ü üliqer* хэмээх болсон ажээ. Академич Ринчений судлагаанаас бүр тодруулан үзвэл, нь дээр өгүүлсэнчилэн түрүүн нэгэнт монголчилсон бичмэлээс шүлэглэх эрдэмтэй, бэлэн үгтэй, авъяаслаг хуурч үлгэрч нар цээжлэн өгүүлэхдээ монгол соносогчийн сэтгэл санаанд нийцүүлэн улам уран сайхнаар найруулж монгол бичигийн хэлээр хэлдэг байна. Тийм ч учраас олон үлгэрч-хуурч бичмэл дэвтэрээ авч явдаг байсан ажээ. Зарим нь нөгөө хүний өгүүлснийг дам цээжлээд баяжуулан найруулж хэлдэг байжээ.

Монгол орчуулгагүй хятад зохиолыг хуурдан өгүүлдэг байсан баримт цөөнгүй бий. Ийм тохиолдолд уг зохиолыг монгол хэл мэддэг хятад сяньшен нараар яриулах буюу орчуулгаад дам боловсруулан өгүүлдэг байж. Ийм сяньшений нэг нь багадаа ар газар ирж монгол хэл бичигт нэвтэрсэн Ван овогт Элбэгбат гэдэг хүн байсан байх ба Богдын хүсэлтээр түүний гараар бичсэн "Жи дан хуушааны намтар", "Ши мэргэний шийтгэсэн хэрэг" зэрэг олон дэвтэр зохиолын орчуулгууд нь

<sup>21</sup> Ринчен "Жанр *bengsen-ü üliqer* в монгольском фольклоре", - *Studia Mongolica*, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959.

<sup>22</sup> В. Rintchen, *Folklore mongol*, Livre premier, - *Asiatische Forschungen*, Band 7, Wiesbaden, 1960.

<sup>23</sup> Муу Охин, *Хүрэлбаатар хүү*, Улаанбаатар, 1961; *Их Жунхэн хатан*, Улаанбаатар, 1963; Д. Цэрэнсодном, *Хятад бичигийн зохиол монгол газар аман уламжлалаар дэлгэрсэн нь*, - Монголын уран зохиолын тойм, 3-р дэвтэр, Улаанбаатар, 1969, 229-236-р таг; G. Kara, *Chants d'un barde mongol*, Budapest, 1970; W. Heissig, *Geschichte der mongolischen Literatur*, Band 1-2, Wiesbaden, 1972; Б. Л. Рифтин, Д. Цэрэнсодном, *Сказ Бэнсэн улигэр и проблема литературно-фольклорных взаимосвязей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 280-314.

<sup>24</sup> А. П. Руднев, *Материалы по говорам Восточной Монголии*, Санкт-Петербург, 1911, стр. 16-19; Б. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Выпуск второй, Петербург, 1920, стр. 3; В. А. Алексеев, *Китайская литература*, - Сборник статей, Выпуск второй, Петербург, 1920, стр. 17; С. А. Кондратьев, *Музыка монгольского эпоса и песен*, Москва, 1970.



хуулбарын хамт Улсын номын санд хадгалагдаж байдагийг академич Б. Ринчен профессор онцлон тэмдэглэжээ<sup>25</sup>.

Бэнсэний үлгэр (оросоор *книжные сказания*; англиар *Narration from book*; францаар *Chantefable* гэж орчуулдаг)-ийг монгол үлгэрч-хуурч нар хэл найруулгын хувьд монгол соносогчийн сэтгэлд нийцүүлэн өөрийн үгээрээ хуурдан гол төлөв шүлэглэн урнаар өгүүлж дам дам ам дамжин уламжладаг учир орчуулгын зохиолоос огт өөр, нэг хэлсэн хувилбар нь дахин давтагддаггүй ажээ.

Бэнсэний үлгэрийн тархацыг үзвэл тэдгээр үлгэрч-хуурч нар нь их төлөв баарин, жаруд, хорчин, харчин, үзэмчин зэрэг өвөрлөгч монголчууд байхаас гадна дорнод монголын халхад нэлээд дэлгэрсэн байдаг; харин баруун монгол, буриадад бараг дэлгэрээгүй байна. 1950-иад он хүртэл Улаанбаатарт бэнсэний үлгэр өгүүлдэг хүмүүс нэлээд байсан боловч гарал үүслийн хувьд дээрхи нутгийнхан зонхилож байсан гэдэг. Иймээс "Бэнсэний үлгэр" бол баруун монголчуудад тархсан туулийн орон зайг дорнод монголчуудын хувьд төлөөлж байжээ гэж үзэж болмоор санагдана. Харин бэнсэний үлгэрийн уг үүслийг хятад нутгийн цайны газруудад бичиг үсэггүй хүмүүст олон өдөр дараалан үлгэр түүх цээжээр өгүүлж цайны газар олон хүн цуглуулдаг шоу шү (說書 буюу 說唱)-тэй холбоотой хэмээн таамаглаж болмоор байна.

Бэнсэний үлгэрийг ая дангийнх нь талаас авч үзвэл багагүй сонирхол татдаг бөгөөд тухайн үлгэрийн үйл явдал бүхэн, жишээлбэл: үлгэр эхлэх ая, мөрь амааллах ая, цэрэг хөдлөх ая, зам хөөх ая, аян дайны ая, уй гашууны ая, дайсныг дарсаны ая, магтаалын ая, хурим найрын ая, төгсгөх ая гэх зэргээр цөм өөр өөрийн өвөрмөц ая дантай байсан бөгөөд академич Ринчений судлагаанаас үзвэл нийтдээ 170 гаруйд хүрдэг байна. Тэрээр 1960 онд Лувсан хуурчийн өгүүлсэн "Бодь мэргэн хаан" үлгэрийг хэвлүүлэхдээ нэлээд аяыг ноотлон хавсаргасан нь монгол хөгжмийн судлалд чухал хэрэглэгдэхүүн болж өгнө<sup>26</sup>.

Манай үлгэрч-хуурч нар бэнсэний үлгэрийн загвараар хятадаас орчуулаагүй өөр үлгэрийг хэлдэгээс гадна болон орчин үеийн магтаалыг зохион хэлдэг уламжлал буй. Ийм үлгэрчийн нэг нь үзэмчиний Цэнд гэдэг хүн одоо амьд сэрүүн байсаар байгаа бөгөөд түүний өгүүлсэн 18 настай Янжин гэдэг идэрхэг баатар охины тухай "Эртний Энэдхэгийн эзэн Шинчү хаан" гэдэг үлгэр болон Сүхбаатар жанжины магтаал зэрэг нь үүний баримт болно<sup>27</sup>.

Бэнсэний үлгэрийг дагалдаж монголын үлгэрч-хуурч нарын дунд хуурчдын гартаах үг, холбоо хэлэх гэх зэрэг олны нүдэн дээр болдог тэмцэлдээн буй болжээ. Ийм тэмцэлдээнийг их төлөв тухайн нутаг хошууны язгууртнууд зохион байгуулж түрүүлэгсэдэд шагнал, тусгай цол

<sup>25</sup> Ринчен "Жанр *benqsen-ü üliqer* в монгольском фольклоре", - *Studia Mongolica*, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959, стр. 5, 8.

<sup>26</sup> Ринчен "Жанр *benqsen-ü üliqer* в монгольском фольклоре", - *Studia Mongolica*, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959, стр. 6; В. Rintchen, *Folklore mongol*, Livre premier, - *Asiatische Forschungen*, Band 7, Wiesbaden, 1960.

<sup>27</sup> Ц. Шагдарсүрэнгийн цуглуулгад буй.

олгодог байсан ба тийм тэмцээн уралдаан нь нэгд, уг эх зохиолын үйл явдалыг нарийн ширийнгүй зөв мэддэг эсэх, хоёрт, хэн нь илүү уран сайхан өгүүлж хуурдаж байна вэ? гэдэг гол шалгууртай байсан төдийгүй бага залуу үлгэрч-хуурчдыг сургах өвөрмөц арга болж байжээ<sup>28</sup>.

Энэ бүхнээс үзвэл монголын аман зохиол дах бэнсэний үлгэр нь тодорхой газар орны хүрээнд сэдэвийн хувьд, хятадаас орчуулсан зохиолоос эхтэй гэж үзэж болох боловч хэл болон ая дангийн хувьд эх зохиолоос харьцангуй чөлөөтэйгөөр монгол үлгэрч-хуурчийн найруулах эрдэм, хөгжимдөх чадалын илэрхийлэл болж өгдөг өвөрмөц төрөл зүйл төдийгүй үлгэрчдийн мэдэлгэ, агшин зуур сэтгэж шүлэглэн зохиомжлох (The improvisation) чадварыг хөгжүүлэх сургууль болсоор ирсэн ажээ.

### 3. Хятадаас орчуулсан зохиол бүтээлийн сэдэв зүйл болон орчуулгын гол төвүүдийн тухай

Хятадаас орчуулсан уран зохиолын зүйлийг хэдэн зууд хүрнэ гэж академич Ринчен үзсэн байдаг<sup>29</sup>. Я. Цэвэлийн боловсруулан нийтлүүлсэн "Улсын Номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал ном бичигийн бүртгэл" хэмээх шинэ зарчимаар 1937 онд анх Монголд гарсан номзүй болон 1960 онд гарсан Жадамбын "Улсын нийтийн номын сангийн бичмэл зохиолын номын гарчиг" зэргээс үзэхэд хятадаас орчуулсан уран зохиол, түүх шаштир, бусад холбогдол бүхий зүйл гээд нийт зохиол бүтээлийн тоо лавтай хэдэн зуу хүрэх нь тодорхой харагдана<sup>30</sup>.

Хятадаас монголчилсон хэдэн зуун зохиол бүтээлүүдийн хувьд орчуулгын талаас нь судласан судлагаанд гол төлөв хятадын эртний уран зохиолын зүйл хамрагдсан байх<sup>31</sup> ба түүх шаштир, анагаах ухаан гэх

<sup>28</sup> Ринчен "Жанр *bengsen-ü üliгер* в монгольском фольклоре", - *Studia Mongolica*, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959, стр. 5; Д. Цэрэнсодном, *Холбоо шүлгийн учир*, - Аман зохиол судлал, Tomus 8, Fasc. 3; Улаанбаатар, 1974; Б. Л. Рифтин, Д. Цэрэнсодном, *Сказ Бэнсэн улигер и проблема литературно-фольклорных взаимосвязей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 312-313.

<sup>29</sup> Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373.

<sup>30</sup> Čebel, *Ulus-un nom-un sang-un Azi-yin anggi-dur бүкүй монгол анги-yin bičmel ba darumal nom bičig-üd-un бүрдкөл*, Улаанбаатар, 1937, (III+161); Jaddungba, *Ulus-un neyitü-yin nom-un sang-un bičmel jokiyal-un nom-un yarǰu*, Улаанбаатар, 1960, (III+117).

<sup>31</sup> Ринчен, *Ойратские переводы с китайского*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. XXX, I, Warszawa, 1966, стр. 59-73; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 371-386; Э. Түмэнжаргал, *Тансан ламын баруун этгээдэд зорцсоныг тэмдэглэсэн түүх гэдэг зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь*, - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 175-210-р тал; Э. Түмэнжаргал, *Сүн улсын хүйтэн уулын бичиг* - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 211-227-р тал; Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 234-279; Boris Riffin, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - *Literary Migrations*,

зэрэг бусад салбарын орчуулгын бүтээлүүд зохих ёсоор тогтолцоотой судлагдаж амжаагүй ажээ. Хэдий тийм боловч хятадаас монголчилосон зохиол бүтээлийн дотор хятадын эртний уран зохиол, гүн ухааны бүтээлүүд багагүй хувийг эзлэдэг учир наад зах нь тэр хүрээндээ монгол орчуулгын уламжлал, онцлогийг илэрхийлж чадна гэж үзэх үндэс буй.

Иймд түрүүн гарсан судлагаануудад үндэслэж цогцод нь авч үзэхэд хятадаас монголчилосон зохиол бүтээлүүдийн ерөнхий онцлог өнөөдөрийн байдлаар аль нэгэн хэмжээгээр харагдана гэж бодож байна.

Хятадаас монголчилосон зохиол бүтээлүүдийн судлагаанд сэдэвийн асуудлыг гол төлөв ангийн үүднээс авч үзээд ардчилсан утга агуулга бүхий гэх буюу нийгмийн дээд давхаргын ялзралыг харуулсан ардач чанартай зохиолууд байна гэх зэргээр тэмдэглэсэн нь тухайн цаг үеийн нөлөө буй заа гэдэгийг тэмдэглэх хэрэгтэй.

Зөвлөлтийн эрдэмтэн Борис Рифтин, В. И. Семанов нар эртний хятадын роман, туужийн монгол орчуулгуудын ерөнхий төлөвийг хятад эх зохиолтой нь харьцуулан номзүйн байдлаар удаа дараа авч үзсэн нь энэ хир хамгийн өргөн хүрээнд хийсэн судлагаа гэж хэлэх үндэстэй юм. Тэхдээ үүнээс өмнө Э. Хэйниш (E. Haenisch), В. Грүбэ (W. Grube), В. Хайссиг (W. Heissig) нар ийм судлагаа хийж байсныг үгүйсгэх аргагүй юм<sup>32</sup>.

Б. Рифтин сүүлчийн өгүүлэлдээ хятадаас монголчилосон томоохон хэлбэрийн уран зохиолыг хамруулж, хятад эхтэй нь харьцуулан тодруулах, түүхэн роман ("Олон улсын түүх", "Долоон улсын дэвтэр", "Жун дагийн тууж", "Баруун Хан улсын бичиг", "Хэ ван юаны бичиг", "Гурван улсын бичиг", "Их Тан улсын хойтыг төвшитгөсөн Хуа Муланы үлгэр", "Их Тан улсын үүсгэлийн түүх", "Их Тан улсын Лүвэ Түнг Сүвэ бэ Юаны бичиг", "Их Тан улсын Шиүвэй Ли-ну зүүн Ляо-г төвшитгөсөн ... бичиг", "Их Тан улсын баруун Лияанг-ыг тогтоогсон бичиг", "Их Тан улсын Шижай Тан-юй бичиг", "Тан улсын бичиг", "Хойт Сүн улсын (үлгэрийн) бичиг", Сүнг Ман хоёр улсын бичиг", "Жияачин хааны үлгэр"...), ёс суртахууны тууж ("Жинг Пинг Мэй хэмээх бичиг", "Шинэ Хун Лэу тэнг", "Пин шанг ланг ен-ий бичиг", "Их Танг улсын Эр дү тэй хэмээх бичиг", "Ху Диеэ тэй хэмээх бичиг", "Ү мэй юаны бичиг", "Шяа-и юан хэмээх бичиг", "Ертөнцийг мандуулагч түүх их Лиү юй сияа-ы үлгэр", "Сүн улсын Ли Ханг хоёр овогт Юан вэй-гийн журмыг илтгэсэн бичиг", Чэн Чай жин;ий түүх", "Чи Линг мэнг"), зөгнөлт тууж ("Тансан ламын үлгэр", "Хувилгаан өргөмжилсөн бичиг", "Шэн Сиян юан хэмээх түүх", "Ү Тү юан хэмээх Жан Тиен си таван хортой шулмасыг дарсан түүх"), илдийн эрдэм хийгээд шүүхийн тууж ("Сүй хү жуан...", "Чэн жэнг ай си бичиг", "Сияау ү йи", "Боо гүнг-ийн бичиг", "Ши мэргэн ноёны үлгэр"), зурагт үлгэр ("Жин гү ци гуан", "Циү сияан-ы цэцэг", "Пай ан жин ши") гэх

---

Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 213-262; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209-212.

<sup>32</sup> E. Haenisch, *Der Chinesische Roman im Mongolischen Schrifttum*, - Ural-Altäische Jahrbücher, Band 30, Wiesbaden, 1958; W. Heissig, *Geschichte der mongolischen Literatur*, Band 1-2, Wiesbaden, 1972.

мэтээр сэдэв болон хэлбэрийн талаас нь ангилаж, нийт жар шахам зохиолыг хамруулсаны хажуугаар тухайн орчуулга хаана хадгалагдаж буй хийгээд Монгол, Орос, Япон, Герман, Унгар, АНУ, Дани, Шведийн номын сангуудад байгаа эсэхийг боломжийн дотор тодруулахыг оролдсон байна<sup>33</sup>. Зохиогч зургаан жилийн өмнөхи хамтын зохиогчтой өгүүлэлдээ тухайлбал: аж байдал, янаг амрагийн сэдэвтэй зохиол ("*Жин, Пин, Мэй*", "*Улаан асарын зүүд*", "*Пинг шан ланг ен-ий бичиг*", "*Их Танг улсын Эл Ду-тэй хэмээх бичиг*", "*Ү Иэй юаны бичиг*" ...) гэх зэргээр үүнээс нэлээд өөрөөр ангилаж байсан ажээ<sup>34</sup>. Гэвч аль аль ангилалыг эргэн нягтлууштай санагдана.

Хятадаас монголчилосон зохиол бүтээлийн бараг ихэнхи нь хэд хэдэн орчуулгатай байх бөгөөд тэр болгоны орчуулагч, орчуулсан цаг үе тодорхойгүй, цөм өөр өөр нэртэй байдаг. Нэг жишээ татахад: Ши Най-анийн "*Шуй-ху жуань*" гэдэг романы монгол орчуулга гэхэд л "*Sui qu juwan*", "*Усан балгамалын бичиг*", "*Голын тохой*", "*Мөрөний хариг*", "*Сэрүүн тунгалаг уулын бичиг*", "*Сүн улсын хүйтэн уулын бичиг*" гэдэг олон нэрээр дайралддаг байна. Монголын бичигийн хүмүүн Гүлранс энэ зохиолыг орчуулж байсан гэх мэдээ буйн дээр бидний мэдэхийн хэрээр Балданцэрэн, Цогбадрах нар орчуулсан гэх баттай баримт буйг дээр өгүүлсэн.

Монгол орчуулгын түүхэнд энэ мэтээр нэг зохиолыг удаа дараа болон нутаг нутагт зэрэг орчуулдаг явдал төвөдөөс монголчилосон орчуулга дээр ч олонтаа дайралддаг байна. Жишээ нь: Сажа Бандида Гунгаажалцаны "*Субашид*"-ыг Соном-Гара, Урудын мэргэн гэгээн Дамбажалсан, Цахар гэвш Лувсанчүлтэм нар тус тус орчуулсан байдаг<sup>35</sup>. Эртний энэдхэгийн "*Damamūkonāmasūtra*" буюу монголчуудын дунд "*Үлгэрийн далай*" гэж алдаршсан зохиолын тухайд Гүүш цорж, Тойн гүүш, Зая бандида Огторгуйн далай (Намхайжамц) болон үл мэдэгдэх орчуулагчийн дөрвөн өөр орчуулга байдаг<sup>36</sup>. Ийнхүү нэг зохиолыг цаг хугацааны хувьд ойролцоо удаа дараа орчуулсаар ирсэнийг тэмдэглэсэн болоод анхааран тусгайлан судласан өгүүлэл бүтээл ч цөөнгүй гарчээ<sup>37</sup>.

Ийнхүү аль нэгэн зохиолыг орон зай болон цаг хугацааны хувьд дахин дахин орчуулах нь зарим талаар олдоцтой холбоотой байж болох

<sup>33</sup> Boris Riftin, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 213-262;

<sup>34</sup> Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 234-279;

<sup>35</sup> James Bosson, *A Treasury of Aphoristic Jewels: The Subhasitaratnanidhi of Sa Skya Pandita in Tibetan and Mongolian*, - Uralic and Altaic series, Vol. 92, Indiana Univer., Bloomington, 1969; *Эрдэнийн сан Субашид*, Улаанбаатар, 1990, 5-21-р тал;

<sup>36</sup> С. Šagdarsüren, *Le Damamūkonāmasūtra texte mongol du Toyin Guisī*, Monumenta Linguae Mongolicae Collecta, Tom. X, Budapest, 1989, pp. V-XVII.

<sup>37</sup> W. Heissig, *Toyin guosi ~ guisi alias Čoxtu guisi: Versuch einer indentifizierung*, - Zentralasiatische Studien, 9, Wiesbaden, 1975, ss. 361- 446; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 59-р тал.

боловч хамгийн гол нь орчуулгын чанар чансааг улам боловсруулан сайжруулах гэсэн буян номын эрмэлзэл болохоос биш зарим нэг хүний бичсэнчилэн мөнгө ашигтай огтхон ч хамаагүй гэж үзэх нь монгол сэтгэлгээнд илүү ойртоно.

Сая хятадын эртний томоохон хэмжээний уран зохиолыг авч үзсэн бөгөөд үүний хажуугаар төр ёсны түүх, шаштир, сургаал номлолын чанартай болон анагаах ухааны салбарын ном бүтээл нэн олноор нь монголчилосон гэдэгийг дахин бодолцох хэрэгтэй гэдгийг эмдэглэе.

Хятадын зохиол бүтээлүүдийн орчуулга хийгээд орчуулагч, тархац зэргээс нь үзвэл лавтайяа өвөрлөгч нутаг, дорнод монгол, төв халх нь хятадын сонгодог зохиол бүтээлийг орчуулах гол төвүүд болж байсан нь харагддаг.

Академич Ринчений судлагаа болон түүнийг батласан шинэ олдвор зэргээс үзэхэд хятадаас орчуулдаг төвүүдийн дээрхи жагсаалт дээр Баруун монгол зохих ёсоор нэмэгдэнэ. Үүнд: Тод бичгээр *"Тансан лам баруун этгээд зорчсон тэмдэглэл"* байсаныг үзсэн тухайгаа академич Ринчен нэг бус удаа тусгайлан тэмдэглэсэн нь монгол орчуулгын уламжлалыг судлахад үнэтэй хэрэглэгдэхүүн болж өгдөг<sup>38</sup>. Зая Бандида Намхайжамцын намтар тэргүүтнээс үзэхэд 12 жилийн дотор төвөдөөс лавтай 177 зохиол орчуулсан гэх жагсаалт байдаг бөгөөд үүний нэлээд олоныг нь хэдийнээ монголоор орчуулчихсан, зарим нь хэд хэдэн орчуулгатай байсан гэж судлагчид тэмдэглэжээ<sup>39</sup>. Иймд *"Тансан лам..."* хэмээх зохиолыг Баруун Монголд хятад хэлнээс нь дахин орчуулж тодоор гаргасан байх бүрэн боломжтой юм. Үүнийг дам батлах баримт ч гарч байна. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн тод номын хөмрөгт угтаа наад зах нь 6 боть байсан зүү төөнийн засал тэргүүтнийг өгүүлсэн анагаах ухааны номын хоёр дэвтэр буй бөгөөд үүнд хавсаргасан зураг, хэлний байдал болон монголчилолгүй тод, төвөд үсгээр галигласан зарим нэр томъёо зэргийг үзэхэд хятад хэлнээс орчуулсан болох нь бэлхэнээ харагддаг. Энэ хоёр боть номыг академич Ринчен 1968 онд гэрэл зургийн аргаар хэвлэн нийтлүүлжээ<sup>40</sup>.

Тэгвэл хятадын олон зохиол дотроос *"Тансан лам..."*-ыг ямар учраас Баруун монголд орчуулав? гэдэг асуулт гарч болно. Хариулт нь арай холоос олдоно гэж бодож байна. Монгол ном бичигийн уламжлалаас үзвэл шашны чанартай номыг сударчилдаг, төрийн буюу иргэнлиг номыг дэвтэрлэн товхидог байсан<sup>41</sup> бөгөөд хятадаас монголчилосон тэр олон зохиол бүтээлийн дотроос *"Тансан лам баруун этгээд зорчсон тэмдэглэл"*, ХҮШ зууны эхээр ван Цэдэнжавын манжаас

<sup>38</sup> Ринчен, *Ойратские переводы с китайского*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXX, I, Warszawa, 1966, стр. 59-73; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373-388;

<sup>39</sup> Х. Лувсанбалдан, *Тод үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 123-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 59-р тал.

<sup>40</sup> *Unknown Medical tractate in oirat characters* I, II, - Corpus Scriptorum Mongolorum, Tomus V, Fasc. 6, 7, Ulanbator, 1968.

<sup>41</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 146-147-р тал.

орчуулсан гэдэг "Жүн дагинын тууж"-ийн зарим хувилбар нь сударчилсан хэлбэртэй, бас маанийн зургаан үсэг нэмсэн зэргийг судлагчид ажин тэмдэглэсэн нь буй<sup>42</sup>. Иймд "Тансан лам..."-ыг шашины утга холбогдолтой хэмээн Баруун монголд сонгож орчуулжээ гэж үзэх үндэслэл гарч байна. Үүнчилэн, урд насандаа оо энгэсгэ тавьж байсан эхийгээ шоолсоны учир хойд насандаа зүс муу төрсөн гэх "Жүн дагина буюу Жүн Ү ян-ы тууж" мөн л шашины утга чанартай болохоор нь монголчууд тэр номыг тийнхүү сударчилсан хэрэг буй заа.

Хятадаас орчуулсан зохиол бүтээл болон бэнсэний үлгэрийн хэл, найруулгын тал нь бусад орчуулгын зохиол, тухайлбал: төвөдөөс үгчилэн орчуулдаг уламжлалаас огт өөр, илүү монголжуу, зарим нь монгол хэлний яруу тансаг найруулгын жишээ болдог, зарим нь уг эхдээ баригдалгүй чөлөөтэй орчуулсан, уг хятад эхдээ үргэлжлүүлсэн зохиолыг монгол орчуулгад нь бүлэглэж хуваасан, зураг чимэглэл нэмж хавсаргасан гэх зэрэг олон онцлог буйг нэлээд эртнээс нэрт монголч Б. Я. Владимирцов, нангиадач В. Алексеев, академич Ринчен нарын зэрэг бас бус судлагчид удаа дараа онцлон тэмдэглэсээр иржээ<sup>43</sup>.

Хятадаас монголчилосон орчуулгууд нь монголчуудыг хятадын сонгодог зохиол бүтээлтэй танилцуулах гүүр болоод зогссонгүй, Хятад газар уг эхээрээ үгүй болсон гэх "Жүн дагинын тууж" (буюу "Жүн Ү ян"), "Цю хайтан" болон энэ хир хятадаараа олдоогүй байгаа бас бус роман туужууд<sup>44</sup> монгол орчуулгаар ийнхүү үлдэн хоцорсон нь монголчуудын хувьд хүн төрөлхтөний соёлын түүх, өв санд оруулсан нэгэн гавъяа гэж үзэх бүрэн үндэстэй ажээ.

---

<sup>42</sup> Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 242-146;

<sup>43</sup> В. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 3; В. А. Алексеев, *Китайская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 17; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 376. Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 272;

<sup>44</sup> В. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 238, 241-243, 263.